Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 01 сарын 10-ны өдрийн 6120 дугаарт бүртгэв.

# ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 22 өдөр Дугаар 61 Улаанбаатар хот

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 тоот тушаалын хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2017 оны 58 тоот тогтоол, 2021 оны 25 тоот тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Т.НАРАНМАНДАХ

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
61 тоот тогтоолын
хавсралт

**Харилцаа холбооны зохицуулах хорооноос шинэчлэн баталсан зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ**

Хүснэгт-1. Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ

| № | Тусгай зөвшөөрлийн төрөл | Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /мян.төгрөг/ | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Монгол Улсын нутаг дэвсгэрт | Улаанбаатарт* | Аймагт ** |
| 1 | Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх | арилжааны телевиз | 4,500.0 | 2,500.0 | 600.0 |
| | | арилжааны радио | 2,500.0 | 800.0 | 200.0 |
| 2 | Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх | Тусгай дугаарт мессежийн үйлчилгээ | 1,500.0 | - | - |
| 3 | Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх | улс хоорондын ярианы үйлчилгээ | 5,000.0 | - | - |
| | | хот, хот хоорондын ярианы/дата үйлчилгээ (үүрэн) | 55,000.0 | - | - |
| | | хот, хот хоорондын ярианы/дата үйлчилгээ (суурин) | 6,800.0 | 1,800.0 | 600.0 |
| | | сансрын хөдөлгөөнт холбоо (iriduim) | 800.0 | - | - |
| | | Интернэтийн үйлчилгээ | 2,000.0 | 1,000.0 | 300.0 |
| 4 | Олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх | Олон нийтийн телевиз | 3,000.0 | | |
| | | Олон нийтийн радио | 1,500.0 | | |
| 5 | Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх | Утастай, утасгүй сүлжээгээр олон суваг дамжуулах үйлчилгээ | 8,000.0 | 3,500.0 | 800.0 |
| | | Хиймэл дагуулын сүлжээгээр олон суваг дамжуулах үйлчилгээ | 15,000.0 | | |
| 6 | Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх | өргөн нэвтрүүлгийн телевиз | 6,000.0 | 3,000.0 | 800.0 |
| | | өргөн нэвтрүүлгийн радио | 2,500.0 | 800.0 | 200.0 |
| 7 | Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх | Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ | 5,000.0 | 3,000.0 | 1,000.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх | Сансрын холбооны сүлжээ | 3,000.0 | | |
| 9 | Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх | Улс хоорондын сүлжээ | 25,000.0 | - | - |
| | | Улс хоорондын транзит урсгал дамжуулах | 12,500.0 | - | - |
| | | Хот, хот хоорондын сүлжээ | 15,000.0 | - | - |
| | | Шуудангийн сүлжээ | 3,000.0 | - | - |
| 10 | Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх | харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх | 1,800.0 | - | - |
| 11 | Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх | дотоодын шуудангийн үйлчилгээ (Хүргэлтийн үйлчилгээ) | - | 1,000.0 | 500.0 |
| 12 | Төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ эрхлэх | төлбөртэй телевиз | 5,000.0 | - | - |
| | | төлбөртэй радио | 2,500.0 | - | - |
| 13 | Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх | Улс хооронд илгээмж | 3,500.0 | - | - |
| | | Улс хоорондын буухиа | 7,000.0 | - | - |

** - Улаанбаатар хотод болон 10 ба түүнээс дээш аймагт үйлчилгээ эрхэлж байвал зохицуулалтын үйлчилгээний хөлсийг улсын нутаг дэвсгэрт гэсэн төлбөрөөр тооцно.*

*** - Улаанбаатар хотод эрхэлдэггүй зөвхөн хөдөө орон нутагт 6 болон түүнээс дээш аймагт эрхлэх бол 6 дахь аймгаас эхлэн нэмэгдсэн аймаг тус бүрийн төлбөрийг 50 хувиар тооцож зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тооцно.*

Хүснэгт-2. Дугаарлалтын зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ

| Дугаарлалтын төрлүүд | Жилийн зохицуулалтын хөлсний хэмжээ / мян.төгрөг / |
|---|---|
| **А. Тусгай дугаар:** | |
| 1. Яаралтай тусламжийн үйлчилгээний зориулалттай дугаарууд | Төлбөргүй |
| 2. Сүлжээний техник,технологийн ашиглалт болон нэмэлт үйлчилгээний зориулалттай дугаарууд | Дугаар бүр 50,0 |
| 3. Тусгай дугаарт мессежний үйлчилгээний дугаар | Дугаар бүр 0,12 |
| 4. Мэдээлэл лавлах үйлчилгээний | |
| 4.1 Энгийн / Улаанбаатар/ | Дугаар бүр 540.0 |
| /Орон нутаг/ | Дугаар бүр 140.0 |
| 4.2 (1800/1900-ABAB, 1800/1900-AABB, 1800/1900-ABBA) / Улаанбаатар/ | Дугаар бүр 1,040.0 |
| 4.3 (1800/1900-ABAB, 1800/1900-AABB, 1800/1900-ABBA) / Орон нутаг / | Дугаар бүр 340.0 |
| 4.4 (1900-1900, 1800-1800, 1800/1900-AAAA) | Дугаар бүр 2,040.0 |
| 5. Интернэтийн үйлчилгээний зориулалттай | Дугаар бүр 200.0 |
| **Б. Угтвар дугаар:** | |
| 1. Улс хоорондын ярианы гарцын угтвар дугаар / 001,002,003,004 гэх мэт/ | 3,000.0• |
| 2. Хот хоорондын ярианы сүлжээний угтвар дугаар | Дугаар тус бүр 100.0 |
| 3. Интернэт протоколд суурилсан улс хоорондын ярианы үйлчилгээний угтвар дугаар 007 79xxxx | Дугаар тус бүр 120 төг |
| **В. Сүлжээний дугаарлалт:** | |
| 1. Цахилгаан холбооны үйлчилгээний 10.000 хэрэглэгчийн багц дугаар / жилийн төлбөр/ | 1,200.0 |
| 2. Цахилгаан холбооны үйлчилгээний 100.000 хэрэглэгчийн багц дугаар / жилийн төлбөр / | 12,000.0 |
| 3. Үүрэн холбооны үйлчилгээний 1.000.000 хэрэглэгчийн багц дугаар / жилийн төлбөр/ | 120,000.0 |

• *("Улс хоорондын ярианы угтвар дугаарын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг эхний жил 50,000,0 мянган төгрөгөөр, дараагийн жилээс энэ төлбөрийн хэмжээний Хүснэгт №2-ын Б. Угтвар дугаар: хэсгийн 1-д заасан хэмжээгээр тооцно.")*

------ oOo --------